



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.04.21 № 1/1277
танай 2025.01.14 -ны № 02 -т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултын дагуу дараах мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна. Үүнд:

1.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан дэмжих талаар салбарын яамнаас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн тухай:

Монгол Улс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Тэгш шан хөлс олгох тухай 100”, “Алагчилахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111”, “Эхчүүдийг хамгаалах тухай 103” дугаар, НҮБ-ын “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенц, “Эмэгтэйчүүдийн аж байдлын тухай Бээжингийн тунхаглал”, “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Женевийн тунхаглал” зэрэг олон улсын гэрээ, конвенцод тус тус нэгдэн орж, охид, эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр олон улсын гэрээ, конвенцын үндсэн зарчим, үзэл баримтлалыг үндэсний хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

2021 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн хамрах хүрээ өргөжиж албан болон албан бус салбарт ажиллаж байгаа ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж байна. Тухайлбал, ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээр хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрхээ эдэлж, үүрэг хүлээх боломжтой болсон.

Хөдөлмөрийн тухай хуулиар ялгаварлан гадуурхалтыг хориглохтой холбоотой зохицуулалтыг тусгайлан зохицуулсан. Тухайлбал, хуулийн 6 дугаар зүйлд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг ... нас, хүйс, ... эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, ... гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглосон. Түүнчлэн хуулийн 7 дугаар зүйлд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээдээс ажилтанд ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглож, түүнээс урьдчилан

сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан заасан.

Хүний эрхийн үндэсний комиссоос /ХЭҮК/ жил бүр танилцуулдаг Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын тухай илтгэлд хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлыг тусгаж, зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль эрх зүйн орчин сайжруулах талаар зөвлөмжийг Улсын Их хурал, Засгийн газарт хүргүүлж байсан. Үүнтэй холбоотойгоор ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтыг хориглох, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх талаарх зохицуулалтыг хуулийн 7, 8, 102 дугаар зүйлээр тус тус зохицуулсан. ХЭҮК-т иргэдээс 2020 онд нийт 790 гомдол, мэдээлэл ирүүлснээс 131 буюу 16.5 хувь, 2021 онд нийт 1,188 гомдол, мэдээлэл ирүүлснээс 246 буюу 20.7 хувь нь хөдөлмөрлөх эрх зөрчигдсөнтэй холбоотой байна. Үүнээс хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийлэлд өртсөн тухай гомдол, мэдээлэл 2020 онд 43, 2021 онд 126, 2022 онд 98, 2023 онд 113, 2024 оны эхний хагас жилд 46, ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн тухай гомдол, мэдээлэл 2020 онд 5, 2021 онд 12, 2022 онд 3, 2023 онд 8, 2024 онд 8 тус тус гарсан байна. Хүний эрхийн үндэсний комисст иргэдээс хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гаргасан гомдлоос харахад ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн талаарх гомдол нилээд хувийг эзэлж байна.

ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТ ХАНДСАН ГОМДОЛ

1	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох	7	7	10	15	29	44	37	20	7	176
2	Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах	17	21	12	45	19	25	27	16	4	186
3	Цалин хөлс авах	15	7	5	15	24	34	5	22	14	141
4	Амрах	3	0	0	0	4	0	0	0	1	8
5	Хувийн аж ахуй эрхлэх	3	6	2	5	6	1	0	0	3	26

6	Албадан хөдөлмөрө өс ангид байх	1	0	0	0	1	4	1	3	1	11
7	Ажлын байрны дарамт	30	19	55	38	43	126	98	113	46	568
8	Ажлын байрны бэлгийн дарамт	5	1	4	9	5	12	3	8	8	55

/Эх сурвалж: Хүний эрхийн үндэсний комиссын захиргааны мэдээ /2024-11-11//

Хөдөлмөрийн гэрээний төрлийг өргөжүүлж, хөдөлмөрийн гэрээний уламжлалт төрлөөс гадна хөдөлмөрийн харилцааны хэв шинжээс хамааран дагалдан суралцах, ажлын бүтэн бус цагаар ажиллуулах, гэрээсээ, зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээтэй холбогдсон зохицуулалтыг шинээр тусгаж, үл өрсөлдөх, сургалтын гэрээний нэмэлт нөхцөлийг тохирох зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон төрлийн хэв шинжийг зохицуулах боломжтой болсон. Ингэснээр аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн бүтээмж өсөх, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангахад эерэг нөлөөтэй.

Уг хуулийн 43.3-т “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.” гэж заасан. Ажилтныг ажил байр болон гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлага тэнцвэртэй зохицуулж, хүүхдийнхээ хөгжил, байдалд ахиц дэвшил гаргах чадварт эерэг нөлөө үзүүлж буй зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, уг зохицуулалттай холбоотойгоор 2023 онд шинээр 756 байгууллага хүүхэд хамгааллын бодлого баталж, 1011 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, 107 аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 7 байгууллага хүүхдийн цэцэрлэгтэй болж албан хаагчдын хүүхдүүдэд ээлтэй орчин бүрдүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар 2660, байгууллага хүүхэд хамгааллын бодлого баталж, 6374 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, 629 аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 75 байгууллага хүүхдийн цэцэрлэгтэй болсон байна.

Түүнчлэн эх, эсхүл эцэг өөрөө хүсвэл 3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөг авч болохоор зохицуулалтыг тусгаж, ажил олгогч ажилтныг хүүхдээ хөхүүлэх өрөөгөөр хангах арга хэмжээг өөрийн боломжоор авахаар зохицуулсан.

Мөн ахмад настан, хүүхэд, хүнд өвчтэй хүмүүсийг асрах ажлыг цалинтай болон цалин хөлсгүйгээр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөнгөвчлөх, нийгэмшүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай

хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд асрахуйн эдийн засагтай холбоотой зохицуулалтыг тусган боловсруулж байна.

2016 оноос эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл, холбогдох тайлан, дүгнэлтийн тухайд:

2016 оноос эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тусгайлсан төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлээгүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг бодлого арга хэмжээнд үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс жил бүр шинэчлэн баталж хэрэгжүүлдэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөрт тухайн жилийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн хүн амын бүлэг тус бүрт зориулсан нэмэлт арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлдэг. Үүнд:

Ахмад настан, залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор сургалтын, ажил зуучлалын, санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийг олгох, суурь ур чадварын сургалт, танхимын болон үйлдвэр дээрх мэргэжлийн сургалтад аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна.

Дээрх үйл ажиллагаанд хамрагдсан иргэдээс эмэгтэйчүүдийн эзлэх хувийг үзвэл санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 2023 онд 2239 иргэн хамрагдснаас 56.8 хувь, 2024 онд 152 иргэн хамрагдснаас 59.8 хувь, Малчдыг малжуулах арга хэмжээнд 2023 онд 1994 иргэн хамрагдснаас 46.9 хувь, 2024 онд 3319 иргэн хамрагдснаас 43.1 хувь, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2023 онд 1106 иргэн хамрагдсанаас 52.1 хувь, 2024 онд 777 иргэн хамрагдсанаас 54.3 хувь, ахмадын санхүүгийн дэмжлэгт 2023 онд 1095 иргэн хамрагдснаас 71.5 хувь, 2024 онд 1414 иргэн хамрагдснаас 69.5 хувь, суурь ур чадварын сургалтад 2023 онд 6663 иргэн хамрагдснаас 67.9 хувь, 2024 онд 7027 иргэн хамрагдснаас 68 хувь, танхимын болон үйлдвэр дээрх мэргэжлийн сургалтад 2023 онд 5063 иргэн хамрагдснаас 65.8 хувь, 2024 онд 3491 иргэн хамрагдснаас 61.8 хувь, аж ахуй эрхлэлтийн сургалтад 2023 онд 7040 иргэн хамрагдснаас 62.5 хувь, 2024 онд 8829 иргэн хамрагдснаас 67.3 хувийг тус тус эмэгтэйчүүд эзэлж байна.


Мөн 2024 оноос эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, зайнаас болон гэрээсээ ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 831 эмэгтэй хамрагдаж, 182.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

3. 2016 оноос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй нийтлэг арга хэмжээ, төсөл хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтэд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрхэн туссан талаар:

2025 оноос эхлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг нас, хүйс, онцлогийн хэлбэрээр нарийвчлан тогтмол гаргах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/50 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгдсэн удирдамжид хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийн үзүүлэлтийг тусгасан.

2025 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд, тухайлбал: хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ болон зарим арга хэмжээнд нэмэлтээр бага насны хүүхэд асардаг эцэг, эх болон байнгын асаргаатай хүн асардаг иргэнийг хамруулахаар зорилтот бүлгийг өргөтгөсөн. Өөрөөр хэлбэл ажилд зуучлах үйлчилгээнд бага насны хүүхэд асардаг эхийг хамруулах, санхүүгийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн зайн, цахим, танхимын сургалтад байнгын асаргаатай иргэнийг асардаг хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэх хүсэлтэй, боломжтой эмэгтэйчүүдийг хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг үзүүлэх "Job center" төвийн үйл ажиллагааг эхлүүлж, Улаанбаатар хотод эхний 4 төвийг 2024 оны 12 дугаар сард нээсэн. Эдгээр 4 төв нь эхчүүд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөлжин ажиллаж байна. 2025 онд "Job center" төвүүдийг хүн амын бүлэг, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар төрөлжүүлэхийн сацуу улсын хэмжээнд тархаан байршуулж аймаг тус бүрд 1 төв, Улаанбаатар хотод 9 төвийг нэмж байгуулахаар төлөвлөөд байна. Мөн эдгээр төвүүдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нийгмийн хамгаалал, нийгмийн халамж зэрэг бусад төрийн үйлчилгээтэй хослон зохион байгуулж "Job Center Plus" төв болгон өргөтгөн хөгжүүлэх ажлыг туршилтын байдлаар хэрэгжүүлднэ.



Л.ЭНХ-АМГАЛАН